



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

**Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний
замналыг өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3, 3.1.19 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороодын иргэдийн зорчих эрэлт хэрэгцээ, удаа дараагийн хүсэлтийг үндэслэж тэдэнд хүлээгдэлгүй, шуурхай үйлчилгээг хүргэх зорилгоор Ч:28 “Сэлх-7 буудал - Ард кино театр - Ривер гарден хотхон” чиглэлийн замналыг Ч:28 “Сэлх-7 буудал-Ард кино театр” болгон өөрчилж нэгдүгээр, Ч:63 “Хан-Хиллс хотхон-Ривер гарден-МУИС-Ард кинотеатр” чиглэлийг шинээр нээж хоёрдугаар, нийтийн тээврийн үйлчилгээний Ч:11 “Хужирбулан - Офицеруудын ордон” чиглэлд хийсэн судалгааны дүнд үндэслэн эргэлтийн хугацааг өөрчлөн гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх чиглэлүүдийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн цагийн хуваарийг боловсруулж 2017 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс үйлчилгээг эхлүүлэн нэгдсэн даалгаварт тусгахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, тухайн чиглэлийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т, үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, шуурхай зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулахад хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн тээврийн газрын 2016 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/51 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/25 дугаар тушаалын 11 дүгээр хавсралтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР

